



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 45

Мандалговь

“Хот тохижуулах газар” ОНӨААТҮГ-ын
Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1.“Хот тохижуулах” ОНӨААТҮГ-т орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

ТУЗ-ийн дарга:	Сайнцагаан сумын Засаг дарга
Гишүүдэд:	Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга
	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга
	Сайнцагаан сумын Байгаль орчны байцаагч
	Аймгийн ИТХ-ын төлөөлөл (Аймгийн ИТХ-ын тэмдэглэлээр)
	Иргэний төлөөлөл (ТУЗ-ын хурлын тэмдэглэлээр)
Нарийн бичгийн дарга:	Аймгийн ОНӨГ-ын дарга

2.Орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан дүрмийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С О Д - Э Р Д Э Н Э